

# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60, 61, 62, 64, 65, 67 дугаар зүйлүүд, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 17.00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж-19/1, өөрийн байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам, бүртгэлийн өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Б.Наранзулыг томилсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Дарга  
Гишүүд

Г.Алтантуяа  
Ө.Алимаа  
Б.Болормаа

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авахыг Гүйцэтгэх захирал Д.Болорт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



*Б. Наранзуул*

Б.НАРАНЗУЛ

ТУЗ-ийн 2019 оны 03-р сарын 18-ны өдрийн  
02 тоот тогтоолын Хавсралт-1



“Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
2019 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт

№	Хэлэлцэх асуудал	Танилцуулах хүн	Хугацаа
1	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах	Б.Наранзул	30 мин
2	Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах	Б.Наранзул	5 мин
3	ТУЗ-ийн гишүүд сонгох, цалин урамшууллын талаар	Б.Наранзул	30 мин

ТУЗ-ийн 2019 оны 03-р сарын 18-ны өдрийн  
02 тоот тогтоолын Хавсралт-2



**“Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
2019 оны ээлжит хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам,  
бүртгэлийн өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт  
бичгийн жагсаалт**

1. “Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурал хуралдуулах зарыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 2444 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг ээлжит хурал хуралдуулах зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 дахь өдөр буюу 2018 оны 04 дугаар сарын 05-ны өдөр байна.

3. Хувьцаа эзэмшигчид нь ээлжит хурлыг зарласан үед дараахь баримт бичигтэй танилцаж болно. Үүнд:

1. Компанийн 2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга

--ooOoo--